



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/160

Чингис хот

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Бага дунд боловсролын тухай хуулийн 15.3, аймгийн Онцгой комиссын 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, сум хоорондын орох гарах, Улаанбаатар хотоос хүндэтгэн үзэх шалтгаан /албан томилолт, эрүүл мэнд, ар гэрийн гачигдал, хүнс тээвэр/-аас бусад иргэдийн орох хөдөлгөөнийг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 16:00 цагаас 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 16:00 цагт хязгаарласугай.

2. Хэрлэн, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх, Галшар сумдын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс түр хугацаагаар зогсоож, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.


3. Сумдын гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, шуурхай штабын бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Бор-Өндөр суманд зорчсон иргэдийн судалгааг гарган коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын эрсдэлийн үнэлгээг хийж 2021 оны 3 дугаар сарын 25-ны 18:00 цагаас өмнө ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт, мөн төрийн байгууллагын албан хаагчдын тус сум руу зорчсон талаарх судалгааг 2021 оны 3 дугаар сарын 25-ны 17:00 цагаас өмнө гаргаж ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

5. Орох, гарах хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан Чингис хотод бүсчилсэн шалган нэвтрүүлэх хяналтын цэг ажиллуулахыг Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Онцгой байдлын газар /Ж.Эрдэнэбат/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДОРБАТ

• 231010438